



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 310

*ТХТ-Т
Улсын Ерөнхий Сайдын
Хамгаалалтадын
Зөвлөлийн
Дэдчлэгийн
Хуралдааны
Худалдаачлыг
Хэрэгжүүлэх
Тогтоолыг
Хэрэгжүүлэх талаар авах
Зарим арга хэмжээний тухай*

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар
тогтоолыг хэрэгжүүлэх талаар авах
зарим арга хэмжээний тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 9.1.2, 16.12-т заасныг тус тус үндэслэн "1955 оны "Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр" болон "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 68 дугаар тогтоолын 1 дэх заалтын 3, 5 дахь дэд заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол, Хятадын "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д 5 жилийн хугацаатай олгосугай.

2. "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг холбогдох стандартад нийцуулэн батлагдсан зураг төслийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх "Ганцмод" боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д зөвшөөрсүгэй.

3. "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Н.Будбаяр)-д даалгасугай.

4. Бүтээн байгуулалтын ажлын төсвийн магадлагдсан дүнд багтаан гүйцэтгэгч, захиалагч нартай санхүүжилтийн З талт гэрээ байгуулан зохих журмын дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасүрэн)-д даалгасугай.

5. "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2024 оны эхний хагаст багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай.

6.“Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын зурvas газрын тусгай хэрэгцээний газартай давхцсан хэсэгт газар ашиглаулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус даалгасугай.

7.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 136 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг (Х.Нямбаатар)-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

